



129

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 119

Мандалговь

Үндсэн хөрөнгө дуудлагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ Нь:

Нэг: Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2012 онд ашиглалтанд орсон, нийт 8,000,000.00(найман сая) төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ДУА 72-26 улсын дугаартай Приус 10 маркын автомашиныг актлан нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.


Хоёр: Хөрөнгө худалдах доод үнийн хязгаарыг 1,000,000.00 (нэг сая) төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Нанжид)-д даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР,



0100291